



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2011 оны 09 сарын 09 өдөр

Дугаар 4/133

Мандалговь

Газар эзэмших эрх дуусгавар
болгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "г" дэх заалт, Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сайнцагаан сумын төвийн 7 дугаар багийн нутаг дэвсгэрт (Найрамдлын гудамж) байршилтай М.Батмөнх, Ю.Даваажав, Д.Уранбаяр, Т.Цогтсайхан нарын 28 дугаар байрны доорх 140 м.кв (0.014 га) 4 айлын нийтийн орон сууцны зориулалттай газрын газар эзэмших эрхийг дуусгавар болгож нийтийн эдэлбэрийн газар болгосугай.

2. Дээрх иргэдийн газар эзэмших гэрээг цуцалж, гэрчилгээг хүчингүй болгохыг Газрын даамал (Л.Хулан)-д үүрэг болгосугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулж аймгийн Засаг даргын 2010 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 31 дугаар захирамжийн холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



С.БАТ-ОРГИЛ